

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2019	Сар	03	Өдөр	05
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Хүнд болон тусгай зориулалттай машин механизмын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2019-03-05		ЗТ-19\03-001	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Барилга угсралт, зам засвар, хөдөө аж ахуй, уул уурхайн үйл ажиллагаанд ашиглагддаг хүнд машин механизм.					
	Даатгалын үндсэн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>- бүх төрлийн галын;</li> <li>- байгалийн /газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, шороон шуурга/</li> <li>- цахилгаан утасны гэмтлээс гарсан;</li> <li>- зам тээврийн хөдөлгөөний үеийн;</li> <li>- гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл;</li> <li>- хулгайн /механизм, тоног төхөөрөмж бүтнээр хулгайд алдагдах/</li> </ul>					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,3% - 0,5%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв

бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

#### ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагч өөрөө гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бөгөөд түүний улмаас учирсан хохирол болон хууль бусаар ашиглаж явснаас үүдсэн аливаа хохирол;
2. Даатгуулагч, түүний ажилтны сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй үед хийсэн аливаа үйлдэл, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон ядарсан үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн хохирол;
3. Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид 14 хоногт багтаан мэдэгдээгүй үед учирсан хохирол;
4. Машин, механизмыг болон түүний эд ангийг зориулалтын бусаар ашигласан, ашиглалтын горимыг өөрчилсөн, даац, ачаалал хэтрүүлсэн, хурд хэтрүүлсэн, урсгал сөрсөн, замын үргэлжилсэн тусгаарлах шугам давсан, улаан гэрлээр уулзвар нэвтэрснээс үүдсэн хохирол;
5. Машин механизмыг мэргэжлийн зөвшөөрөлгүй, туршлагагүй, даатгуулагчтай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулаагүй этгээдэд ашиглуулсан, жолоо бариулснаас үүссэн хохирол;
6. Зориулалтын бус аргаар машин механизмыг халаах, асаах, чирэх, чирэгдэх оролдлого хийх болон түрэх, түлхэх оролдлого хийснээс үүдсэн хохирол;
7. Даатгуулагч, түүний жолоо барих эрх олгосон этгээд жолоочийн албан журмын даатгалд хамрагдаагүй, жолоодох эрхийн үнэмлэхгүй, жолоодох эрх нь хасагдсан үед учирсан хохирол болон зам тээврийн ослын хэрэг нь шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагаар шалгагдаж байгаа этгээд жолоодсоноос үүдсэн хохирол;
8. Тоормосны систем, дугуй, жолооны механизм нь ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэлтэй, техникийн зөрчилтэйгөөр хөдөлгөөнд оролцсоноос үүдэн гарсан хохирол;
9. Даатгалын зүйл дотор байсан эд зүйлс, тээвэрлэж явсан зорчигч, ачаанд болон тэдгээрээс үүдэн гарсан хохирол, бусдад буюу гуравдагч этгээдэд учруулсан хохирол;
10. Байгалийн бус газар хөдлөлт, чичиргээ, хөрсний гулгалт, нуралтын улмаас учирсан хохирол;
11. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийн зөвшөөрөгдсөн байршил өөрчлөгдсөн, бусдад барьцаалуулах, түрээслэх, зээлдүүлэх, болон ашиглуулах үед гарсан хохирол;
12. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийг тээвэрлэх үед гарсан хохирол;
13. Ашиглалтын хугацаа заасан эд ангиуд болон туслах, дагалдах материалуудыг;
14. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
15. Үйлдвэрлэлийн дефектээс болон буруу суурилуулсан, угсарсан, задалснаас үүдэн гарсан болон тэдгээрийг засварласан аливаа зардал;
16. Операторын илт хайхрамжгүй, санаатай үйлдлийн улмаас үүссэн аливаа хохирол;
17. Даатгалын тохиолдлын бус үед зайлшгүй сэргээн засварлахтай холбогдон гарах зардал;
18. Хадгалалтын горим зөрчсөн, урсгал засвар болон зайлшгүй хийгдэх засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд хийгээгүйгээс үүдсэн хохирол;
19. Дугуйн гадуур бүрээс, олгойд учирсан хохирол;
20. Даатгуулагч нэг удаагийн төлөлтөөр даатгалын хураамжийг төлөх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан боловч хураамжаа төлөөгүй байх үед эсхүл даатгалын хураамжийг хэсэгчилж төлөх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан боловч гэрээнд заагдсан хуваарийн дагуу эхний төлбөрөө төлөөгүй байх үед үүссэн хохирол;
21. Хууль тогтоомжид заасан бусад.